

**“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН
ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН 2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

(2021 оны жилийн эцсийн байдлаар)

2022.01.12

НЭГ. ЗОРИЛГО

Монгол Улсын Их хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн Барилга, хот байгуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хийж гүйцэтгэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж хүргүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтанд бодит мэдээлэл өгөх, төрийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах, дэмжлэг үзүүлэх зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг зорилтот түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан үнэлж, жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Их хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д туссан 8 зорилтын хүрээнд 28 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2021 оны жилийн эцсийн байдлаар **96,4** хувьтай, **“тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэлэв.

Үндсэн чиглэлд тусгагдсан нийт 28 арга хэмжээнээс 100 хувьтай 20 арга хэмжээ, 90 хувьтай 7 арга хэмжээ, 70 хувьтай 1 арга хэмжээ байна.

Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг харуулбал:

№	Бодлогын зорилго, зорилт, арга хэмжээ	Зорилтот түвшин	Хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
Зорилго 2. Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.				
Зорилт 2.5. Эрүүл баталгаат орчныг бий болгоно:				
1	Арга хэмжээ 2.5.2 Орон сууц, ногоон байгууламжийн стандартыг олон улсын түвшинд хүргэж, шинэчилнэ.	1.БНБД-ийн төслийг мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна. 2.Хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлсэн байна.	”Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх” /БНБД 31-01-10/-ийг шинэчлэн боловсруулж, Хот байгуулалт, архитектурын мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн барьж, 2020.11.04, УИХ-ын нэгдсэн чуулганы 2020.11.06-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлсэн.	90
2	Арга хэмжээ 2.5.3 Агаар, ус, хөрсний бохирдол болон дуу чимээг багасгаж, цэвэр,	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж дуусган, ИД-2025/2021 тоот экспертизийн нэгдсэн дүгнэлтийг гаргуулан,	100

	ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлнэ.	боловсруулах ажлыг зохион байгуулна.	БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗ-ийн 2021.12.10-ны өдрийн хурлаар, БХБ-ын сайдын зөвлөлийн 2021.12.15-ны өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлсэн.	
3	Арга хэмжээ 2.5.6 Хот суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын далан, сувгийн өндөржилтийн нэгдсэн зураг төсөл боловсруулна.	УБ хотын ХУД, СХД, БГД-ийн өндөржилтийн нэгдсэн зураг төсөл болон УБ хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний Мастер төлөвлөгөө боловсруулсан. 2021 онд шинээр 8 км үерийн усны далан суваг ашиглалтад орсон.	100
Зорилго 3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангах тогтолцоог бий болгож, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.				
Зорилт 3.2. Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ:				
4	Арга хэмжээ 3.2.1 Нийгмийн даатгал төлдөг бага, дунд орлоготой иргэдийг анх удаа орон сууц худалдан авахад нь урьдчилгаа төлбөргүй, орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулдаг тогтолцоог бий болгоно.	Ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийг бууруулах талаар санал боловсруулж, шийдвэрлүүлнэ.	Урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээдэд урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах"-тай холбогдсон нэмэлт, өөрчлөлтийг Зээлийн батлан даалтын тухай хуульд тусган боловсруулж, УИХ-аар 2021.11.12-ны өдөр хэлэлцүүлэн батлуулсан.	100
5	Арга хэмжээ 3.2.2 Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци байгуулж, орон сууцжуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн хэрэгжүүлж эхэлнэ.	Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци байгуулах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	Энэ асуудлыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021.04.29-ний өдрийн 6 дугаар хуралдаанаар хэлэлцэж, нийслэл өөрийн өмчийн компанийг татан буулгах сонирхолгүй байгаагаа илэрхийлсэн. Иймээс нийслэлээс шалтгаалан түр хойшлоод байна.	90
6	Арга хэмжээ 3.2.3 Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бий болгоно.	Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бий болгох тооцоо, судалгааг боловсруулж, тодорхой санал боловсруулсан байна.	Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээдийн урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах." гэсэн нэмэлт, өөрчлөлтийг оруулж, УИХ-аар 2021.11.12-ны өдөр батлуулсан.	100
7	Арга хэмжээ 3.2.4 Барилгын цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулж, бага өртөгтэй орон сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ.	1.Эрдэнэтийн гангийн үйлдвэрийн барилгын ажлыг дуусгаж, тоног төхөөрөмж суурилуулсан байна. 2. Барилгын хавтгай шилний үйлдвэр барих төсөл боловсруулж, холбогдох газарт хүргүүлнэ. 3.Баруун бүсэд Ховд-Эко цементийн үйлдвэрийн барилгын ажлыг	Эрдэнэтийн гангийн үйлдвэрт зээл олгох хүсэлтийг Хөгжлийн банкинд уламжилсан. Хавтгай шилний чиглэлээр "Эрдэс плазм" ХХК-ийн төслийг хамгийн хэрэгжих боломжтой төсөл гэж үзэж дэмжин ажиллаж байна. Баруун бүсэд Ховд-Эко цементийн үйлдвэрийн барилгын ажлыг дуусгасан. Ажлын гүйцэтгэл 97%.	70

		дуусгаж, ашиглалтад оруулна.		
Зорилт 3.6.Монгол Улсын газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ:				
8	Арга хэмжээ 3.6.1 Газрын харилцаа, хот байгуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хотуудын зэрэглэлийг тогтоосон байна.	1.Хуулийн төслүүдийг боловсруулж, үзэл баримтлалыг батлуулсан байна. 2. Газрын багц хууль болон Геодези, зураг зүйн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна.	Газрын багц хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулсан. Хуулийн төслийг боловсруулсан. БХБСайдын зөвлөл болон Газрын шинэтгэлийн үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлж, дэмжигдсэн. УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрөл авахаар бэлтгэж байна. Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгээд байна. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчлсэн найруулгын төслийг 2020.01.22-ны өдөр УИХ-д өргөн барьсан.	100
9	Арга хэмжээ 3.6.2 Хаягжилтын нэгдсэн системийг Монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулна.	Улсын төсвийн санхүүжилтээр Хаягийн мэдээллийн нэгдсэн системийг байгуулах зөвлөх үйлчилгээний ажлыг хийж дуусгана.	“Хаягийн мэдээллийн нэгдсэн систем байгуулах” ажлыг “Геомастер” ХХК-гүйцэтгэж, “Топ сүрвэй” ХХК захиалагчийн техникийн хяналтыг хийсэн. эцсийн шатны гүйцэтгэлийг хүлээн авч, санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.	100
10	Арга хэмжээ 3.6.3 Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын систем бий болж, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлнэ.	Мониторингийн сүлжээний 500 цэгт газрын төлөв байдал, чанарын судалгаа хийж, мэдээллийн санд оруулна.	Газрын мониторингийн сүлжээний бэлчээрийн газрын байнгын ажиглалтын мониторингийн 500 цэгт газрын төлөв байдал, чанарын хэмжилт, судалгааг хийж, үр дүнг Газрын мониторингийн цахим системийн мэдээллийн санд оруулсан.	100
11	Арга хэмжээ 3.6.4 Монгол Улсын геодезийн сүлжээг шинэчлэн сайжруулж, нийт нутаг дэвсгэрийг бүх төрлийн масштабын байр зүйн зургаар бүрэн хангана.	Бүх төрлийн масштабын байр зүйн зураг боловсруулах, өндрийн шугамыг хэмжих, сүлжээг тэгшитгэн бодох, газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг зохион байгуулна. Байнгын ажиллагаатай станцын удирдлагын программ хангамжийг сайжруулна.	“Туул-1 коллекторын трассын дагуух геодези, байр зүйн зургийн ажил М1:500 /Улаанбаатар/”, “Өндрийн 1-р ангийн 1 шугамыг хэмжих, сүлжээг тэгшитгэн бодох” ажил, 3 аймгийн 10 суманд газар зүйн нэрийн тодруулалтын ажил зэрэг ажлыг гүйцэтгэсэн. Нийт нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах ажлын санхүүжилтийг 2021 оны улсын төсөвт тусгуулахаар саналаа СЯ-нд хүргүүлсэн боловч санхүүжилт шийдвэрлэгдээгүй.	90
12	Арга хэмжээ 3.6.5 Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлж, үйл ажиллагааг нь эхлүүлнэ.	Газрын биржийн програм хангамжийг хэрэглээнд нэвтрүүлж, газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг цахимаар зохион байгуулна.	2021 оны 12 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр нийт 2147 газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааг газрын биржийн mle.mn системээр зохион байгуулж, нийт 4179 иргэн, хуулийн этгээд оролцож, 11	100

			тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.	
13	Арга хэмжээ 3.6.6 Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж, орон зайн төлөвлөлтийг хийнэ.	Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн судалгаа, төлөвлөлтийг боловсруулах ажлыг зохион байгуулна.	“Хүн амын өсөлт, хөдөлмөрийн зах зээл, нийгмийн дэд бүтэц”, “Аж үйлдвэр дэд бүтэц”, “Хүн амын нутагшилт, суурьшил” зэрэг 3 боть ХАНСХЕТ-ний эцсийн тайланг боловсруулж дуусаад байна.	100
Зорилго 4. Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, нефть, шатахууны дотоодын хэрэгцээг өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлсэн улс болно.				
Зорилт 4.2 Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ:				
14	Арга хэмжээ 4.2.7 Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн эрчим хүч, инженерийн дэд бүтцийг хөгжүүлнэ.	"Тайшир-Алтай ус хангамжийн төсөл"-ийг хэрэгжүүлнэ.	Монгол Улсын Говь-Алтай аймаг, Есөнбулаг болон Тайшир сумын нутаг дэвсгэрт Алтай хотын хүн амыг ундны усаар хангах "Тайшир-Алтай ус хангамжийн төсөл"-ийг хэрэгжүүлж дуусган, комисс ажиллан барилга байгууламжийг ашиглалтад оруулаад байна.	100
Зорилго 8. Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагалт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлнэ.				
Зорилт 8.1. Эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбоно:				
15	Арга хэмжээ 8.1.5 Чөлөөт бүс, хилийн боомтуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийж, олон улсын стандартад нийцүүлэн, нэвтрэх чадварыг нэмэгдүүлнэ.	1.“Алтанбулаг”, “Замын-Үүд”, “Бичиг” хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулсан байна. 2. Замын-үүд чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулсан байна.	“Алтанбулаг, Замын-Үүд, Бичиг хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг Хилийн боомтын үндэсний зөвлөлийн 2021.06.15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. “Замын-Үүд чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулж, мэргэжлийн зөвлөл, Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэн, дэмжигдсэн.	100
16	Арга хэмжээ 8.1.8 Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд эхний ээлжинд алслагдсан зарим аймгуудад гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр “Аймаг, сумын төвийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийг Баян-Өлгий, Увс, Ховд,	Төслийн зээлийн эх үүсвэрийг тодорхойлох хүрээнд холбогдох зээлийн хэлэлцээр боловсруулах, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тодотголоор тусгуулсан байна.	Төслийг “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тусгуулж, хэрэгжүүлэхээр Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн. Төслийн баг аймгуудын хөгжлийн чиг баримжааны баримт бичгийг боловсруулж байна.	90

	Дорнод аймгуудад хэрэгжүүлнэ.			
17	Арга хэмжээ 8.1.10 Аймаг, сумын төвийг бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамруулж, сумдад “Сумын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Төслийг 5 сумын төвд хэрэгжүүлнэ.	Баянхонгор аймгийн Өлзийт сум, Өвөрхангай аймгийн Хайрхандулаан суманд хэрэгжиж буй төслүүд дууссан. Хэнтий аймгийн Галшар, Баянхонгор аймгийн Галуут, Эрдэнэцогт сумдад хэрэгжиж байна.	100
Зорилго 9. Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.				
Зорилт 9.3. Хотын төвлөрлийг задалж дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ухаалаг технологийн шинэчлэл хийнэ:				
18	Арга хэмжээ 9.3.1 Соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв баригдаж төвлөрлийг бууруулна.	“Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” -ний баримт бичгийн төслийг боловсруулсан байна.	21 чиглэлээр судалгаа, үнэлгээний ажил болон хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил дуусаад байна. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичигт экспертиз хийж, мэргэжлийн зөвлөл болон Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжигдсэн.	100
19	Арга хэмжээ 9.3.2 Хот дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.	Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд ашиглалтад орсон орон сууцны тоо	Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд 2021 онд аймгуудад 893, нийслэлд 695 айлын орон сууц тус тус ашиглалтад орсон.	100
20	Арга хэмжээ 9.3.3 Инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ технологийг нэвтрүүлнэ.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймаг, нийслэлийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээг шинэчлэн сайжруулж, хүчин чадлыг 30 хувиар нэмэгдүүлнэ.	цэвэр усны 78,1км, бохир усны 12,6 км, дулаан хангамжийн 1,1 км, цахилгааны 0,8км, үерийн хамгаалалтын 8км, гэрэлтүүлгийн 235км шугам сүлжээгээр инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг 30 хувиар нэмэгдүүлсэн.	100
Зорилт 9.4. Хууль, эрх зүйн шинэчлэл хийж, хотын засаглал, эдийн засаг, нийгмийн таатай орчныг бүрдүүлнэ:				
21	Арга хэмжээ 9.4.1 Хотын засаглалын оновчтой тогтолцоог бүрдүүлэн бүх шатны төлөвлөлт, төлөвлөгөөг боловсруулах, батлах, шийдвэр гаргахад иргэд, олон нийтийн оролцоог хангаж, иргэдийн мэдээлэл олж авах сувгийг нээлттэй, хүртээмжтэй, ил тод болгоно.	“Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” -ний баримт бичгийг боловсруулсан байна.	Энэ ажлын хүрээнд Хот байгууллалтын иж бүрэн үнэлгээ, Хүн ам зүйн судалгаа, Нийгмийн дэд бүтцийн судалгаа, Орон сууцны судалгаа, Эдийн засгийн судалгаа зэрэг нийт 21 судалгаа, үнэлгээний ажил хийгдэж дуусан ба хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил 90%-тай байна.	90
22	Арга хэмжээ 9.4.3 Дархан, Эрдэнэт болон бусад том хотуудыг улсын зэрэглэлтэй болгож, хөрөнгө оруулалт, ажлын байрыг нэмэгдүүлэх хууль, эрх	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгөх, ХАНСХЕТ-тэй уялдуулан хот, суурин газарт улс, орон нутгийн зэрэглэл тогтоох судалгаа,	Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгсөн. Дархан, Эрдэнэт зэрэг улсын зэрэглэлтэй хот байгуулах болон аймгийн төвүүдийг хот болгох эрх зүйн орчныг бүрдүүлэхэд шаардлагатай судалгаа, тооцоо, санал боловсруулж,	100

	зүйн таатай орчныг бүрдүүлнэ.	тооцоо, саналыг боловсруулсан байна.	ЗГХЭГ-т 2021.11.16-ны өдрийн 2/4520 тоот албан бичгээр хүргүүлсэн.	
Зорилт 9.5. Хөрөнгө оруулалтын шинэ боломж бүрдүүлж, үйлдвэрлэлийн бүс нутгийг тэлнэ:				
23	Арга хэмжээ 9.5.1 Олон төвт хотын тогтолцоог хэрэгжүүлж, “Шинэ Зуунмод”, “Майдар” шинэ дагуул хотын бүтээн байгуулалтыг эхлүүлж, инженерийн шугам сүлжээ, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлсэн байна.	1. Шинэ Зуунмод хотын ерөнхий төлөвлөгөө, үе шатны зураг төсөл боловсруулагдсан байна. 2. Майдар шинэ дагуул хотын Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулагдсан байна.	Төв аймгийн Хөшигийн хөндий дэх шинэ хотуудын нэгдсэн төлөвлөлтийн /концепци/-ийг боловсруулж ЗГ-ын хуралдаанд 2021 оны 6-р сарын 30-ны өдөр танилцуулж, 38 дугаар тэмдэглэл гарсан. Төв аймгийн Хөшигийн хөндий дэх бүтээн байгуулалтын асуудлыг хариуцсан захиргаа байгуулах асуудлыг Засгийн газрын тогтоолын төслийг ЗГ-ын 2021 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 234 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн. Майдар хот төслийн хот байгуулалтын иж бүрэн үнэлгээний баримт бичгийг боловсруулж экспертизийн нэгдсэн дүгнэлт гаргуулсан.	90
24	Арга хэмжээ 9.5.2 Зүүн хойд Азийн зорчигч, ачаа тээврийн нэгдсэн зангилаа төв болгох ажлыг эрчимжүүлж, Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг ашиглалтад бүрэн оруулна.	Богд хаан төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр, логистикийн нэгдсэн төвийн инженерийн дэд бүтцийн судалгаа, эх үүсвэрийг тодорхойлох зураг төсөл” боловсруулах ажлыг зохион байгуулна.	БНСУ-ын “Чэйл консорциум” ХХК нь Майдар хотын усны эх үүсвэрийн урьдчилсан тандан судалгаа хийх ажлыг эхлүүлээд байна. Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээ, ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, харилцаа холбооны зураг төслийн даалгаврыг батлуулж, зураг төслийг боловсруулж байна.	90
25	Арга хэмжээ 9.5.3 Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлж эхэлсэн байна.	Засгийн газрын 2021 оны 53 дугаар тогтоолоор “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-г батлуулсан байна.	Засгийн газрын 2021 оны 53-р тогтоолоор “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө” боловсруулан батлуулсан. Энэхүү төлөвлөгөөнд бохирдуулагч үйлдвэрийн хаягдал усны хэмжээ, бохирдлын түвшинг хянах лаборатор байгуулах, үйлдвэрийн технологи үйл ажиллагаанд шинэ техник, технологи нэвтрүүлэх, норм, нормативын баримт бичгийг шинээр боловсруулах, шинэчлэх зэрэг 60 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэн ажиллаж байна.	100
26	Арга хэмжээ 9.5.4 Дагуул хотуудад дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн парк=уудыг байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.	Хонхорт БМҮТПарк байгуулах ажлыг дэмжиж ажиллана.	“Эрдэс плазм” ХХК-д Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 227 дугаар тогтоолын дагуу ҮТПаркын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгосон. Мөн Хонхорт БМҮТПарк байгуулахыг дэмжиж, 2021 оны 11 дүгээр сарын 24-25-ны	100

			өдрүүдэд материалын нийлүүлэлтийн зохион байгуулсан.	"Барилгын ханган форум"-ыг	
27	Арга хэмжээ 9.5.5 Хот, тосгоныг холбосон хурдны тойрог зам дагуу аялал жуулчлалын цогцолборуудыг байгуулж, монгол брэндийн худалдааны төвийг нээн ажиллуулна.	ХАНСХЕТ төсөл боловсруулагдсан байна. Зам дагуу аялал жуулчлалын цогцолборуудыг байгуулахтай холбоотой судалгаа боловсруулагдсан байна.	ХАНСХЕТ төслийн хүрээнд эцсийн тайланг боловсруулаад байна. "Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө" төслийн хүрээнд зам дагуу аялал жуулчлалын цогцолборуудыг байгуулах, орон нутаг дахь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих худалдааны төв байгуулах чиглэлээр судалгаа хийж, туршилтын "Мичино эки" төслийг хэрэгжүүлсэн.		100
28	Арга хэмжээ 9.5.6 цахим эдийн засаг, үйлчилгээний салбарыг дэмжихэд шаардлагатай дэд бүтэц болох Улаанбаатар хотын дагуул хотыг барьж байгуулна.	1.Хөшигийн хөндийн шинэ хотын нэгдсэн төлөвлөлтийн концепцийг боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулсан байна. 2.Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээ, ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн зураг төслийг боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээний дагуу ажлыг гүйцэтгүүлнэ.	1.Төв аймгийн Хөшигийн хөндий дэх шинэ хотуудын нэгдсэн төлөвлөлтийн концепцийг боловсруулж Засгийн газрын 2021.06.30-ны өдрийн хуралдаанд танилцуулж 38 дугаар тэмдэглэл гарсан. 2.Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээ, ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, харилцаа холбооны зураг төслийн даалгаврыг батлуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, зураг төслийг боловсруулж байна.		100
Үндсэн чиглэлийн 2021 оны хэрэгжилт					96,4%

Дараах томоохон арга хэмжээг 2021 онд хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

Ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийг бууруулах хүрээнд СЯ, ХНХЯ-тай хамтран банк, санхүүгийн байгууллагаас орон сууц хуалдан авах зориулалтаар зээл авахыг хүссэн, урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээдэд урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах"-тай холбогдсон нэмэлт, өөрчлөлтийг Зээлийн батлан даалтын тухай хуульд тусган боловсруулж, УИХ-аар 2021.11.12-ны өдөр хэлэлцүүлэн батлуулсан.

Хот байгуулалтын тухай хуулийн шинэчлсэн найруулгын төслийг 2020.01.22-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн ба УИХ-ын ЭЗБХ-ны 2020.11.04-ний өдрийн, УИХ-ын нэгдсэн чуулганы 2020.11.06-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцэн, хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэхийг дэмжсэн.

"Алтанбулаг, Замын-Үүд, Бичигт хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг Хилийн боомтын үндэсний зөвлөлийн 2021.06.15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.

"Шинэ Зуунмод", "Майдар" хотууд, Төвийн бүсийн тулгуур төв Зуунмод хот, босоо тэнхлэгийн олон улсын хурдны АН-3 автозам, "Богдхан төмөр зам" тэдгээрийг даган бий болох чөлөөт бүс, тээвэр логистикийн нэгдсэн төв, инженерийн дэд бүтцийн төсөл, хөтөлбөрүүдийг

цогцоор нь хэрэгжүүлэх орон зайн нэгдсэн төлөвлөлтийн асуудлыг Засгийн газрын 2021.03.24-ний өдрийн хуралдаанд танилцуулан, мөн өдрийн 19 дүгээр тэмдэглэл гаргуулсан.

Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд 2040 он гэхэд Зүүн хойд Азийн зам тээврийн (агаарын, төмөр зам, авто замын) томоохон зангилаа төв бүхий 150 мянга хүртэл хүн амтай эдийн засгийн өндөр өсөлттэй бүс нутаг, түүнийг даган бий болсон аеротрополис хот бий болгох нэгдсэн төлөвлөлтийн концепцийн төслийг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, Засгийн газрын 2021.06.30-ны өдрийн хуралдаанд танилцуулан 38 дугаар тэмдэглэл гарсан.

Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 307 дугаар тогтоолоор Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт 19390.4 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авч, газрын хилийн заагийн эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээг батлуулсан.

Газрын мониторингийн сүлжээний бэлчээрийн газрын байнгын ажиглалтын мониторингийн 500 цэгт газрын төлөв байдал, чанарын хэмжилт, судалгааг хийж, үр дүнг Газрын мониторингийн цахим системийн мэдээллийн санд оруулсан.

Нийт 2147 газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааг газрын биржийн me.mn системээр зохион байгуулж, нийт 4179 иргэн, хуулийн этгээд оролцож, 11 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Эрчимжүүлэх шаардлагатай, 70 хувьтай 1 арга хэмжээ байна. Үүнд:

Арга хэмжээ 3.2.4 Барилгын цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулж, бага өртөгтэй орон сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ.

2021 онд хүрэх түвшин:

1.Эрдэнэтийн гангийн үйлдвэрийн барилгын ажлыг дуусгаж, тоног төхөөрөмж суурилуулсан байна. 2. Барилгын хавтгай шилний үйлдвэр барих төсөл боловсруулж, холбогдох газарт хүргүүлнэ. 3.Баруун бүсэд Ховд-Эко цементийн үйлдвэрийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна.

Бүрэн хэрэгжээгүй нөхцөл шалтгаан:

-Барилгын ажилд шаардагдах санхүүжилтын эх үүсвэр байхгүй, тус яам санхүүжилтийг бие даан шийдэх боломжгүй, зөвхөн зээлийн хүсэлтийг уламжилдаг.

-Дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдал хүнд, гадаад хил гааль дээр хорио, хязгаарлалт тавигдаж, үйлдвэрүүд түүхий эд, хүний нөөцөө татан ажиллуулахад хүндрэлтэй байсан.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Монгол Улсын Их хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д туссан Барилга, хот байгуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээний 8 зорилт, 28 арга хэмжээний хэрэгжилт 2021 оны жилийн эцсийн байдлаар **96,4** хувьтай, “**тодорхой үр дүнд хүрсэн**” гэж дүгнэв.

Бага дунд орлоготой иргэдийг жилийн 4-6 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлд хамруулах арга хэмжээний хүрээнд Ипотекийн зээлийн хүүг 6 хувь болгож, санхүүжилтийг нэмэгдүүлсэний үр дүнд жилийн эцсийн байдлаар арилжааны банкуудад нийт 1.012.0 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 13,292 зээлдэгчидэд олгож 2020 онтой харьцуулахад даруй 2.5 дахин өссөн үзүүлэлттэй байна.

2021 оны Төсвийн тухай хуульд Барилга, хот байгуулалтын сайдын багцад батлагдсан 97 арга хэмжээ, Зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах-145, нийт 242 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнгээр гэрээ байгуулахаас 2021 оны жилийн эцсийн

байдлаар **228** төсөл, арга хэмжээний 187,3 тэрбум төгрөгийн гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

"Тайшир-Алтай" төслийг амжилттай хэрэгжүүлснээр Алтай хотын хүн амыг баталгаат ундны усаар хангаж, Монгол Улсын хэмжээнд анх удаа гадаргын усыг унд, ахуйн хэрэглээнд ашиглах жишиг төсөл болж чадсан.

ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Газрын багц хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн хууль, Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулга, шинэчлэн боловсруулж дуусган яаралтай УИХ-д өргөн барьж батлуулахад холбогдох газрууд анхаарч ажиллах;

2. "Барилгын цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулж, бага өртөгтэй орон сууцаар хангах тогтолцоог бүрдүүлэх" зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодит арга хэмжээг яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх;

3. "Аймаг, сумын төвийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр" төслийг Баян-Өлгий, Увс, Ховд, Дорнод аймгуудад хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг ханган, төслийг эхлүүлэх;

4. Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25 000 масштабтай байр зүйн зургаар зурагжуулах, байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээлэл, газрын биржийн удирдлагын нэгдсэн төв байгуулах зэрэг ажлуудын санхүүжилтийг Сангийн яамтай хамтран шийдвэрлүүлэх;

5. "Шинэ Зуунмод", "Майдар" хотуудын засаг захиргааны нэгж, бүтэц, нутаг дэвсгэрийн хилийн цэсийг тогтоох судалгаа хийх арга хэмжээний хөрөнгө санхүүжилт мөн шийдэгдээгүйгээс шалтгаалан арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй байдалт хүрч байна. Иймд төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дээрх зайлшгүй хэрэгжүүлэх, томоохон төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай байна.

6. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгагдсан, 90 хувьтай, бүрэн хэрэгжүүлж дуусгах 7 арга хэмжээг 2022 оны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэхийг яамны холбогдох газар, хэлтсийн дарга нарт даалгах;

7. Цаашид Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2023 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах арга хэмжээг төлөвлөхдөө шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг "Алсын хараа-2050", Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан оновчтой, зөв тодорхойлоход анхаарч ажиллахыг зөвлөж байна.

Тайлбар:

"Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн хэрэгжилт болон 1-5-р хавсралтуудыг хүргүүлж байна.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

О.ЛХАГВЭЦЭДЭН

БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ

Б.ОЮУНЧИМЭГ

